



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг улаанбаатар төмөр зам”-ын гүйцэтгэсэн Хангай-Багахангай хоорондын замын 508-р км-ийн гармын жижүүрийн байр, Паш хаалтаар тоноглох холбоо, гадна цахилгаан, сирдп тоног төхөөрөмж суурилуулах угсралтын ажил”-ыг хүлээн авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Дагвадорж	Дүүргийн менежер
Гишүүд:	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Ч.Цоггэрэл	Улаанбаатар төмөр замын 2 дугаар ангийн Багахангай дахь 17 дугаар хэсгийн мастер
Нарийн бичиг:	Г.Хишигт	Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр ангийн засварын инженер

2. Ашиглалтад хүлээн авах ажлын чанар, гүйцэтгэлд хууль, журмын дагуу хяналт тавин зохион байгуулж, эргэн танилцуулахыг Ажлын хэсэг (Г.Дагвадорж) -т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

11230140